



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 28-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.02.28 № 03

Барилга, байгууламж газар  
хөдлөлтөд тэсвэртэй эсэх талаар

Иргэдээс ирүүлж буй санал хүсэлтэд Улаанбаатар хот төдийгүй аймаг сумдад баригдаж буй барилгуудын чанар, норм, стандарт, ялангуяа газар хөдлөлтийн талаарх асуудал цөөнгүй дурдагдаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд хандан дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Газар хөдлөлтийн судалгаанаас харахад манай улсын хот, суурин газрын 75 орчим хувь нь 7 ба түүнээс дээш, 12 сум, суурин газар 9-өөс дээш баллын газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт оршиж байна. Үүнээс 7-оос дээш баллын газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт хүн амын 86 хувь нь амьдарч байна гэсэн судалгааг 2019 онд гаргажээ. Тиймээс улсын хэмжээнд баригдсан болон одоо барьж байгаа нийт барилга байгууламж, тэр дундаа орон сууц, олон нийтийн барилгын газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт тэсвэртэй эсэх талаарх мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, хичнээн тооны барилгууд газар хөдлөлтөд тэсвэргүй болон тэсвэртэй эсэх талаарх тоон мэдээллийг бүсчлэл болон байршлаар нь;

2. Иргэн бүр өөрийн ажиллаж, амьдарч буй барилга, байгууламжийнхаа чанар, аюулгүй байдлын талаарх мэдээллийг олж авах, танилцах боломжтой эсэх болон энэ талаарх эрх зүйн орчин бүрдсэн эсэх;

3. Барилга байгууламж барих зөвшөөрөл олгохоос эхлэн барьж байгуулах, бүх шатны хяналт тавих, тохируулах, зүгшрүүлэх, ашиглалтад оруулах, хүлээн авах зэрэгтэй холбоотой зөрчил, доголдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа болон, хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, стандарт зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хэрхэн бүрдүүлсэн талаар;

4. Түүнчлэн Барилгын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн тухай статистик мэдээллийг сүүлийн 10 жилийн байдлаар зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ОДОНТУЯА

2023000007